



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/007-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-21
4. Аудитын тайлан	21-25
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	25-30
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	31-32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОХНС	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх
ГХУСАХЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТХС	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХА	Хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.ХАДБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № ЦАА - 2025/007-МА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 152 дугаар тогтоолоор тайлант онд 9,888,519.6 мянган төгрөгийн татварын орлого, 580,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 10,468,519.6 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 13,595,891.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 29.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 29 төсөл, арга хэмжээнд 4,465,616.9 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 14 төсөл, арга хэмжээнд 3,150,914.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 15 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, сумын хөрөнгө оруулалтаар нийт 12 төсөл, арга хэмжээнд 1,356,268.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 5 төсөл, арга хэмжээнд 486,486.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 7 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Мандал сумын Засаг дарга нь тайлант онд 5 зорилт, 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.9 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,054,743.00	12,085,858.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,462,978.30	7,214,263.90
33	АВЛАГА	885,495.80	686,398.50
35	БАРАА МАТЕРИАЛ	3,706,268.90	4,185,195.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,171,165.60	22,282,549.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,171,165.60	22,282,549.90
39200	Биет хөрөнгө	16,559,278.30	20,406,431.70
39300	Биет бус хөрөнгө	611,887.30	1,876,118.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	25,225,908.60	34,368,408.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	229,439.90	323,207.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	229,439.90	323,207.00
41300	Өглөг	229,439.90	323,207.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,996,468.70	34,045,201.10
51	Засгийн газрын хувь оролцоо	24,996,468.70	34,045,201.10
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,107,916.90	6,107,916.90
51200	Хуримтлагдсан үр дүн	17,303,583.60	26,352,316.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,584,968.20	1,584,968.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	25,225,908.60	34,368,408.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	17,150,683.50	24,153,274.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,307,811.90	12,909,317.90
110	Орлогын албан татвар	6,418,999.40	10,101,458.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,835,111.80	10,645,108.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-416,112.40	-543,649.80
113	Хөрөнгийн албан татвар	821,828.20	828,574.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,066,984.30	1,979,285.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,638,092.50	7,562,743.60
120	Нийтлэг татварын бус орлого	5,638,092.50	7,562,743.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,204,779.10	3,681,212.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,589,101.70	11,787,322.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,589,101.70	11,787,322.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,341,171.80	9,717,462.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,871,554.00	2,646,555.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,859.00	326,357.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,688.20	2,712,107.50
2104	Хангамж, бараа материалын зардал	192,809.00	182,665.40

2105	Нормативт зардал	173	550
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,555.10	402,197.90
2107	Томилолт, зочны зардал	11,881.60	13,346.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,767,862.90	2,049,823.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	867,789.00	1,383,858.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,247,929.90	2,069,860.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,561,581.80	12,365,952.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,780,095.20	3,309,496.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,781,486.60	9,056,455.50

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,743,303.00	18,156,889.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,307,811.90	12,657,994.70
110	Орлогын албан татвар	6,418,999.40	10,101,458.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,835,111.80	10,645,108.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-416,112.40	-543,649.80
113	Хөрөнгийн албан татвар	821,828.20	828,574.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,066,984.30	1,727,962.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	294,481.10	436,551.30
1181	Газрын төлбөр	487,925.60	1,103,231.60
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	284,577.60	188,179.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,123,741.50	1,063,475.30
120	Нийтлэг татварын бус орлого	1,123,741.50	1,063,475.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,311,749.70	4,435,419.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,859,139.20	10,666,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,859,139.20	10,666,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,610,601.80	8,404,241.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,871,554.00	2,646,551.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,859.00	326,357.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,188.20	2,708,495.30
2104	Хангамж, бараа материалын зардал	206,371.70	159,957.20
2105	Нормативт зардал	443	1,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	187,210.80	428,594.40
2107	Томилолт, зочны зардал	9,529.60	12,626.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,796,958.20	1,848,372.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,487.20	272,186.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,248,537.40	2,262,358.50

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,884,163.80	7,490,289.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,880,706.90	3,689,003.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,880,706.90	3,689,003.80
2200	Дотоод эх үүсвэрээр	3,880,706.90	3,689,003.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,880,706.90	-3,689,003.80
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-215,000.00	-50,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	215,000.00	50,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-211,543.10	3,751,285.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,674,521.40	3,462,978.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,462,978.30	7,214,263.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,224,182.00	0	22,224,182.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,199.90	0	-9,199.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,214,982.10	0	22,214,982.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	2,781,486.60	0	2,781,486.60
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,996,468.70	0	24,996,468.70
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	24,996,468.70	0	24,996,468.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,723.10	0	-7,723.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,988,745.60	0	24,988,745.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	9,056,455.50	0	9,056,455.50

20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	34,045,201.10	0	34,045,201.10
----	---------------------------------------	---------------	---	---------------

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,617,894.10	11,872,923.50	3,744,970.60	76.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,337,328.90	8,185,522.30	1,151,806.60	87.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,092,974.40	8,050,907.00	1,042,067.40	88.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,799,954.40	2,644,409.50	155,544.90	94.44
210101	Үндсэн цалин	1,281,000.20	1,292,001.80	-11,001.60	100.86
210102	Нэмэгдэл	1,462,126.10	1,094,902.90	367,223.20	74.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,320.00	103,573.97	-87,253.97	634.64
210104	Урамшуулал	17,775.00	153,857.59	-136,082.59	865.58
210105	Гэрээт ажлын хөлс	22,733.10	73,171.20	-50,438.10	321.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	350,539.20	326,089.80	24,449.40	93.03
210201	Тэтгэврийн даатгал	240,039.50	227,304.70	12,734.80	94.69
210202	Тэтгэмжийн даатгал	27,537.90	26,451.00	1,086.90	96.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,030.10	13,794.40	235.70	98.32
210204	Ажилгүйдлийн даатгал	13,681.80	11,616.40	2,065.40	84.90
210205	Эрүүл мэндийн даатгал	55,249.90	46,923.30	8,326.60	84.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,211,685.90	2,708,495.30	503,190.60	84.33
210301	Гэрэл, цахилгаан	464,342.80	404,425.40	59,917.40	87.10
210302	Түлш, халаалт	2,265,113.60	1,956,671.00	308,442.60	86.38
210303	Цэвэр, бохир ус	481,229.50	346,898.80	134,330.70	72.09
210304	Байрны түрээс	1,000.00	500.00	500.00	50.00
2104	Хангамж, бараа материалын зардал	149,302.00	146,820.90	2,481.10	98.34
210401	Бичиг хэрэг	24,773.00	24,175.50	597.50	97.59
210402	Тээвэр, шатахуун	60,636.30	59,541.40	1,094.90	98.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,213.60	12,205.50	1,008.10	92.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,591.70	37,805.70	-214.00	100.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,087.40	13,092.90	-5.50	100.04
2105	Нормативт зардал	1,100.00	1,100.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100.00	1,100.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	501,791.90	437,712.10	64,079.80	87.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,000.00	22,909.60	1,090.40	95.46
210602	Тавилга	10,000.00	10,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	467,791.90	404,802.50	62,989.40	86.53
2107	Томилолт, зочны зардал	15,797,400.00	12,626,560.00	3,170,840.00	79.93
210702	Дотоод албан томилолт	15,797,400.00	12,626,560.00	3,170,840.00	79.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,032,677.40	1,751,250.70	281,426.70	86.15

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,024,654.10	1,745,673.50	278,980.60	86.22
210803	Даатгалын үйлчилгээ	4,710.00	3,618.00	1,092.00	76.82
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,415.20	724.30	690.90	51.18
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	626.50	96.50	530.00	15.40
210807	Газрын төлбөр	1,271.60	1,138.30	133.30	89.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,126.20	22,402.20	7,724.00	74.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,191.20	10,752.50	7,438.70	59.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,935.00	11,649.70	285.30	97.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,354.50	134,615.30	109,739.20	55.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,354.50	134,615.30	109,739.20	55.09
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	113,189.60	13,731.80	99,457.80	12.13
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	108,729.00	104,858.80	3,870.20	96.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,435.90	16,024.70	6,411.20	71.42
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,821,885.20	3,637,401.20	2,184,484.00	62.48
220001	Барилга байгууламж	53,768.90	0	53,768.90	0.00
222001	Тоног төхөөрөмж	100,000.00	0	100,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	5,668,116.30	3,637,401.20	2,030,715.10	64.17
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	458,680.00	50,000.00	408,680.00	10.90
230001	Эргэж төлөгдөх зээл	458,680.00	50,000.00	408,680.00	10.90
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,617,894.10	12,713,303.60	2,904,590.50	81.40
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,325,131.90	12,340,817.30	-15,685.40	100.13
320001	Орон нутгийн төсвөөс	8,696,972.90	8,839,629.70	-142,656.80	101.64
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,628,159.00	3,501,187.60	126,971.40	96.50
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,292,762.20	372,486.30	2,920,275.90	11.31
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	321,600.00	366,982.30	-45,382.30	114.11
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,184.00	5,504.00	-320.00	106.17
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,965,978.20	0	2,965,978.20	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	187	179	8.00	95.72
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	5	5	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	91	87	4.00	95.60
620001	Удирдах ажилтан	15	15	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	38	45	-7.00	118.42
620003	Үйлчлэх ажилтан	27	22	5.00	81.48
620004	Гэрээт ажилтан	11	5	6.00	45.45
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	91	87	4.00	95.60

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34	30	4.00	88.24
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30	40	-10.00	133.33
650010	Гэрээт ажилтан	15	5	10.00	33.33
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	12	12	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	934,231.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	934,231.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,927.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,142.00
210104	Урамшуулал	2,142.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	267.75
210201	Тэтгэврийн даатгал	267.75
2104	Хангамж, бараа материалын зардал	13,136.25
210401	Бичиг хэрэг	2,005.00
210402	Тээвэр, шатахуун	11,131.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,345.00
210604	Урсгал засвар	17,345.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,261.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,261.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,975.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	755,304.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	752,304.35
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	752,304.35
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	934,231.89
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	934,231.89
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,886.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,128.47
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	909,217.39

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Мандал сумын ТТЗ гэх/ нь 2024 оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүнээ дээдэлж, үйлдвэрлэлтийг дэмжиж хамтын хүчээр сумаа хөгжүүлье” гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилтын хүрээнд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Төр иргэний харилцан итгэлцлийг хангасан чадварлаг засаглалын бодлогыг хэрэгжүүлэх,
- Иргэн бүрийг хөдөлмөрлөх ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулах,
- Орон нутгийн түүхий эдийн бааз суурь дээр тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2024 онд Мандал сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,142,499.5 мянган төгрөгөөр буюу 36.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,462,978.30	7,214,263.90	3,751,285.60
Авлага	885,495.80	686,398.50	(199,097.30)
Бараа материал	3,706,268.90	4,185,195.80	478,926.90
Үндсэн хөрөнгө	17,171,165.60	22,282,549.90	5,111,384.30
Нийт хөрөнгө	25,225,908.60	34,368,408.10	9,142,499.50
Өр төлбөр	229,439.90	323,207.00	93,767.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	24,996,468.70	34,045,201.10	9,048,732.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	25,225,908.60	34,368,408.10	9,142,499.50

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн үлдэгдэл 34,368,408.1 мянган төгрөг болж, 9,142,499.5 мянган төгрөгөөр өссөн нь аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 3,462,978.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 7,214,263.9 мянган төгрөг болж, 3,751,285.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	3,462,978.30	7,214,263.90	3,751,285.60
Дүн	3,462,978.30	7,214,263.90	3,751,285.60

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНХО-ын дансанд 5,466,520.9 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 1,214,145.4 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 450,083.7 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний дансанд 83,513.9 мянган төгрөг зэрэг нийт 7,214,263.9 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 885,495.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 686,398.5 мянган төгрөг болж, 199,097.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		6395.8	6,395.80
Хувь хүмүүст олгосон зээл	35,276.50	33,322.20	(1,954.30)
Зээлийн хүүгийн авлага	850,219.30	646,680.50	(203,538.80)
Дүн	885,495.80	686,398.50	(199,097.30)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд ХХС-тай холбоотой зээлийн 646,680.5 мянган төгрөг, зээлийн хүүгийн 33,322.2 мянган төгрөг зэрэг нийт 680,002.7 мянган төгрөгийн авлага, сумын ИТХ-ын 121.5 мянган төгрөгийн, ЗДТГ-ын 6,274.3 мянган төгрөгийн авлага тус тус тайлагнагдсан байна. Нийт авлагаас хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг тодруулбал:

- ✓ 2009-2021 оны үндсэн зээлийн авлагын 104,463.3 мянган төгрөгийн, зээлийн хүүгийн авлагын 1,082.8 мянган төгрөгийн зэрэг нийт 105,546.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн авлага бүртгэлтэй байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 3,706,268.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,185,195.8 мянган төгрөг болж, 478,926.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	15,077.80	15,077.80	-
Эм боох материал	127.5	127.5	-
Бичиг хэргийн материал	6,402.20	4,508.50	(1,893.70)
Аж ахуйн материал	47,205.60	81,653.40	34,447.80
Сэлбэг хэрэгсэл	10,999.40	12,299.40	1,300.00
Барилгын засварын материал	34,934.50	40,884.80	5,950.30
Бусад хангамжийн материал	3,560,121.90	3,999,244.40	439,122.50
Мал амьтад	31,400.00	31,400.00	-
Дүн	3,706,268.90	4,185,195.80	478,926.90

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 478,926.9 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 3,533,366.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, хандив, бусад эх үүсвэрээр 4,555.1 мянган төгрөгийн бараа, материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 432,506.6 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн,
- 378,495.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 2,632,073.1 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг бараа материалын дансаар дамжуулан ашиглагч байгууллагуудад тус тус шилжүүлсэн гэх мэт.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 17,171,165.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 22,282,549.9 мянган төгрөг болж, 5,111,384.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	16,559,278.30	20,406,431.70	3,847,153.40
Барилга, байгууламж, орон сууц	7,476,526.30	9,621,959.10	2,145,432.80
Авто-тээврийн хэрэгсэл	323,399.40	466,477.10	143,077.70
Машин тоног төхөөрөмж(компьютер)	763,381.60	1,052,124.80	288,743.20
Тавилга, аж ахуйн эд хогшил	128,910.50	100,492.70	(28,417.80)
Зам гүүрийн байгууламж	5,562,560.10	6,922,423.70	1,359,863.60
Дуусаагүй барилга	1,438,103.20	1,438,103.20	-
Бусад үндсэн хөрөнгө	865,946.20	804,400.10	(61,546.10)
Ном	451.00	451.00	-
Биет бус хөрөнгө	611,887.30	1,876,118.20	1,264,230.90
Программ хангамж	2,255.00	1,565.00	(690.00)
Бусад биет бус хөрөнгө	609,632.30	1,874,553.20	1,264,920.90
Дүн	17,171,165.60	22,282,549.90	5,111,384.30

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,111,384.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 51,602.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хандиваар 351,720.4 мянган төгрөгийн барилга, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө хүлээн авсан, аймаг, сумын ОНХС-ийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 6,107,499.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, 49,600.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, данс хооронд 1,294.7 мянган төгрөгийг шилжүүлсэн болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 563,007.9 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, бүртгэсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд 1,438,103.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- Тарнийн 8 дугаар багийн барилгын 40,000.0 мянган төгрөгийн /цэвдэгтэй газар баригдаад улсын комисс ашиглалтад хүлээж аваагүйгээс/,

- Түнхэл тосгоны төрийн албан хаагчийн байр болон соёл спортын цогцолборын барилгын 1,078,366.4 мянган төгрөгийн /Барилгын хөгжлийн төвөөс зөвшөөрөл гараагүйгээс улсын комисс хүлээж аваагүй байна/ ,
- ЗДТГ-ын 3-р багийн тоглоомын талбайн 319,736.8 мянган төгрөгийн /гэрээт ажил тайлант онд хийгдэж дуусаагүй, он дамжин хэрэгжсэн/ дуусаагүй барилга тус тус бүртгэлтэй байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 229,439.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 323,207.0 мянган төгрөг болж, 93,767.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг		7,987.00	7,987.00
Байгууллагад төлөх өглөг	229,439.90	314,939.00	85,499.10
Хувь хүмүүст төлөх өглөг		281.00	
Дүн	229,439.90	323,207.00	93,767.10

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөрийн үлдэгдэлд: Зам засварын үлдэгдэл санхүүжилтийн байгууллагад төлөх 29,206.9 мянган төгрөгийн, ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын барьцаа 252,512.6 мянган төгрөгийн, орон нутгийн ерөнхий орлогын 33,219.5 мянган төгрөгийн, сумын ИТХ-ын ажилчидтай холбоотой 1,712.7 мянган төгрөгийн, ЗДТГ-ын ажилчидтай холбоотой 6,274.3 мянган төгрөгийн өр төлбөр тус тус тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 24,996,468.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 34,045,201.1 мянган төгрөг болж, 9,048,732.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,107,916.90	6,107,916.90	-
Хуримтлагдсан үр дүн	17,303,583.60	26,352,316.00	9,048,732.40
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,584,968.20	1,584,968.20	-
Дүн	24,996,468.70	34,045,201.10	9,048,732.40

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 152 дугаар тогтоолоор Мандал сум нь тайлант онд 10,468,519.6 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 13,595,891.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 129.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/					
д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумын төсвийн татварын болон татварын бус орлого	10,468,519.6	13,595,891.6	3,127,372.0	129.9
2	Сумын төсвийн татварын орлого	9,888,519.6	12,909,317.9	3,020,798.4	130.5
3	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын суутган	6,583,113.7	8,316,525.6	1,733,411.9	126.3
4	Үйл ажиллагааны орлого	1,121,800.0	1,489,301.9	367,501.9	132.8
5	Хөрөнгийн орлого	530,336.5	556,077.6	25,741.1	104.9
6	Хөрөнгө борлуулсны орлого	289,835.1	283,203.0	(6,632.1)	97.7
7	Бууны албан татвар	13,000.0	13,356.3	356.3	102.7
8	Малд ногдуулах албан татвар	280,000.0	264,650.0	(15,350.0)	94.5
9	ҮХХАТатвар	550,000.0	550,567.9	567.9	100.1
10	Улсын тэмдэгтийн хураамж	100,000.0	150,980.6	50,980.6	151.0
11	Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	5,000.0	113,410.5	108,410.5	2,268.2
12	Хог хаягдал үйлчилгээ	150,000.0	172,160.2	22,160.2	114.8
13	Газрын төлбөр	305,000.0	341,616.4	36,616.4	112.0
14	дуудлага худалдааны орлого	110,000.0	1,012,938.5	902,938.5	920.9
15	ХХОАТ-ын буцаалт	(543,649.8)	(543,649.8)	-	100.0
16	Ойн нөөц ашигласны төлбөр	368,243.1	183,141.6	(185,101.5)	49.7
17	Ус рашаан ашигласны төлбөр	1,306.0	1,398.1	92.1	107.1
18	Агнуурын нөөц ашигласны төлбөр	4,535.0	3,416.2	(1,118.8)	75.3
19	Байгалийн ургамал ашигласны төлбөр	20,000.0	223.4	(19,776.6)	1.1
20	Сумын төсвийн татварын бус орлого	580,000.0	686,573.6	106,573.6	118.4
21	Бусад орлого	180,000.0	125,669.4	(54,330.6)	69.8
22	Торгуулийн орлого	400,000.0	560,904.3	160,904.3	140.2

Орлогын төлөвлөгөө 3,127,372.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар, үйл ажиллагааны, газрын дуудлага худалдааны орлого зэрэг орлогууд тус тус төлөвлөгөөнөөс давсантай холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,733,411.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой,
- Дуудлага худалдааны орлого 902,938.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь газрын дуудлага худалдаанд оролцох иргэдийн тоо өссөнөөр дуудлага худалдааны анхны үнэ өсөж, орлого нэмэгдсэн,
- Үйл ажиллагааны орлого 367,501.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь сүү, ноос, ноолуур, хүнсний ногооны урамшуулалд хамрагдсан иргэдийн тоо өссөн, мөн урд оны самрын борлуулалтад ногдуулсан татварыг барагдуулах арга хэмжээ авч ажилласантай холбоотой,
- Торгуулийн орлого 160,904.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь хувь хүний хариуцлагын асуудалтай холбоотой торгууль ихээр бичигдсэнээс,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 108,410.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь Бороо гоулд ХХК нь урд оны 90,500.0 мянган төгрөгийн татварын өрийг барагдуулсантай тус тус холбоотой байна.

Тасарсан орлого:

- Ойн нөөц ашигласны төлбөр 185,101.5 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант онд мод бэлтгэлийн аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж, мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагааг зогсоосноос,
- Бусад орлого 54,330.6 мянган төгрөгөөр тасарсан нь тус орлогын тодорхой хэсгийг бүрдүүлдэг байсан үнэт цаасны хураамж, тамхины зөвшөөрлийн үнэ болон бусад хураамжийн орлогууд улсын тэмдэгтийн хураамжийн орлогод төвлөрснөөс тус тус шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 6,448,531.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 115 дугаар тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 9,842,170.9 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 65,184.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 2,305,764.4 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,486,997.0 мянган төгрөг,

- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 606,406.7 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 231,600.0 мянган төгрөг, ХХС-ийн эхний үлдэгдлээс 235,000.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **16,773,123.0** мянган төгрөг, зарлагыг **14,847,075.0** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт **1,926,048.0** мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 152 дугаар тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 656,348.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 10,468,519.6 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 95,184.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 2,334,024.2 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,628,159.0 мянган төгрөг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 557,458.0 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 231,600.0 мянган төгрөг, ХХС-ийн эхний үлдэгдлээс 235,000.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **17,549,944.8** мянган төгрөг, зарлагыг **15,617,894.1** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг **1,932,050.7** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогыг 13,595,891.6 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 109,974.0 мянган төгрөгөөр, ХХС-ийн эргэн төлөлтийн 262,512.3 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,501,187.6 мянган төгрөгөөр зэрэг нийт **17,469,565.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, **1,932,050.7** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **11,872,923.5** мянган төгрөг буюу 76.0 хувьтай тайлагнагдсан нь ХХС-ийн зээл болон ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна. Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- ✓ Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 155,544.8 мянган төгрөгөөр,
- ✓ Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 24,449.4 мянган төгрөгөөр,
- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 503,190.6 мянган төгрөгөөр,
- ✓ Хангамж, бараа материалын зардал 2,481.0 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардал 64,079.8 мянган төгрөгөөр,
- ✓ Албан томилолтын зардал 3,170.8 мянган төгрөгөөр,

- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 281,426.7 мянган төгрөгөөр,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардал 7,723.9 мянган төгрөгөөр,
- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 6,411.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 12 төсөл, арга хэмжээнд 1,356,268.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 5 төсөл, арга хэмжээнд 486,486.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 7 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 29 төсөл, арга хэмжээнд 4,465,616.9 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 14 төсөл, арга хэмжээнд 3,150,914.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 15 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “*нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд эхний үлдэгдэл 226,009.6 мянган төгрөг байсан бол:

- Газрын дуудлага худалдааны дэнчингийн 416,283.3 мянган төгрөг,
- ОНХС, ОНХО-аар хийгдсэн ажлын баталгааны 5 хувийн барьцаа 124,524.9 мянган төгрөг,
- Иргэдэд худалдсан өвс, ногоон тэжээлийн үнэ 87,143.3 мянган төгрөг,
- Алтны уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход 16,210.0 мянган төгрөг, захиалагчийн хяналтын орлого 5,108.1 мянган төгрөг,
- Статистикийн хэлтсээс мал тооллогод 4,728.5 мянган төгрөг,
- Аймгийн ЗДНХ-өөс шагналд 3,000.0 мянган төгрөг, шатахуунд 548.4 мянган төгрөг,
- Аймгийн Биеийн тамир спортын газраас бүх нийтийн гүйлт зохион байгуулахад 800.0 мянган төгрөг, Баянгол сумын цэрэг татлагын хүнсэнд 300.0 мянган төгрөг зэрэг нийт **884,656.1** мянган төгрөг,

ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-ын ГХУСАХЗ-аас явган хүний гэрэлтдэг гарцын санхүүжилтэд зориулж 14,600.0 мянган төгрөг,

Ойн ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд ХАА-н менежмент, тогтвортой байдлыг хангах төслөөс ойн арчилгааны зардалд 18,000.0 мянган төгрөг, үнэт цаасны үнэ 4,038.1 мянган төгрөг,

Түнхэл тосгоны захирагчийн албаны нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагуудаас бохир ус соруулсны төлбөрт 11,600.0 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-аас шатахуунд 693.1 мянган төгрөг,

Хэрх тосгоны захирагчийн албаны нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-аас шатахуунд 644.5 мянган төгрөг, нийт 5 байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд **934,231.8** мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс:

- ✓ Цалин, урамшуулалд 2,409.8 мянган төгрөг,
- ✓ Хангамж бараа материалын зардалд 13,136.2 мянган төгрөг,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардалд 17,345.0 мянган төгрөг,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 122,261.6 мянган төгрөг,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 23,775.0 мянган төгрөг,
- ✓ 1 удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 3,000.0 мянган төгрөг
- ✓ Дуудлага худалдааны орлогын дансанд 250,117.8 мянган төгрөг, дэнчингийн буцаалт 116,456.2 мянган төгрөг, ОНХС, ОНХО-аар хийгдсэн ажлын баталгааны 5 хувийн барьцааны буцаалт 72,245.2 мянган төгрөг зэрэг нийт **620,746.8** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 313,485.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд аймаг, сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн харьцуулалт болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Сумын ОНХС	12	3,823,453.2	3	288,162.0	9	3,535,291.2
Сумын ОНХО	8	1,591,176.4	6	390,312.0	2	1,200,864.4
Аймгийн ОНХО	3	200,000.0	3	200,000.0		
Аймгийн Замын сан	3	180,000.0	3	180,000.0		
Аймгийн ОНХС	1	48,506.0	1	48,506.0		
Нийт дүн	27	5,843,135.6	16	1,106,980.0	11	4,736,155.6

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч цаашид *Мандал сумын ТТЗ гэх*-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/191 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 9,589,101.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 95,891.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зардлуудыг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 503,190.6 мянган төгрөгөөр,
- ✓ Хангамж, бараа материалын зардлыг 2,481.0 мянган төгрөгөөр,
- ✓ Бичиг хэргийн зардлыг 597.5 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардлыг 64,079.8 мянган төгрөгөөр,
- ✓ Албан томилолтын зардлыг 3,170.8 мянган төгрөгөөр,

- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 281,426.7 мянган төгрөгөөр гэх мэт.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 46 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад ЗДТГ-т дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ ЗДНХ-өөс сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс Мал эмнэлэг үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээтэй холбогдуулан 40 малын эмч, мал эмчид **2,067.0** мянган төгрөгийн гарын бэлэг өгсөн гэх мэт.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	ТТЗ	145	141	4	
2	Засаг даргын тамгын газар	171	168	3	
3	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	170	1	
4	Хэрх тосгоны Захирагчийн алба	171	169	2	
5	Түнхэл тосгоны Захирагчийн алба	171	169	2	
6	Ойн анги	171	170	1	
	Нийт дүн	1000	987	13	

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд бүрэн хэрэгжсэн 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид олгох санхүүжилтээс суутган тооцож авах ёстой чанарын баталгааны барьцааны дүнд баталгаажаагүй магадалшгүй ажлын зардал болон гүйцэтгэгч байгууллагад олгох ёсгүй санхүүжилтуудыг оруулж тооцсон нийт **35,895.0 мянган** төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	Төсөвт өртөг	Магадалшгүй ажлын зардал	Техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардал	Зураг, төсвийн үнэ	Захиалагчийн хяналтын зардал
1	"Зүүнхараа гудамжны 0.32 км хатуу хучилттай авто зам барих /6-р баг/ "	Голден дрийм ХХК	300,000.0	5,090.4			
2	"Мөнгөн хараа чуулгаас нүхэн гарц хүртэлх 0.28 км хатуу хучилттай авто зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол барих /7-р баг/ "	Голден дрийм ХХК	447,380.2	6,625.2	5,938.5		
3	"Нэгдсэн эмнэлгээс Вест дэлгүүр хүртэл 0.24 км хатуу хучилттай авто зам барих /9-р баг/ "	Голден дрийм ХХК	365,223.6	5,090.8	4,472.6		618.2
4	"Гудамжны шороон зам засварлах"	Си Эйч Би энд коллеги ХХК	280,000.0	4,888.5			
5	"Хаягжуулалт"	Хос ерөөл инженеринг ХХК	164,393.7	2,670.8			
6	"Хэрх тосгоноос Ажнайн даваа хүртэлх хайрган зам засвар /Мандал сум.Хэрх 4-р баг, Түнхэл 5-р баг/ "	Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК	864,393.7			500.0	
	Нийт дүн		2,421,391.2	24,365.7	10,411.1	500.0	618.2

- Голден дрийм ХХК гүйцэтгэсэн 3 төсөл, арга хэмжээний 16,806.4 мянган төгрөг, Си Эйч Би энд коллеги ХХК гүйцэтгэсэн 1 төсөл, арга хэмжээний 4,888.5 мянган төгрөг, Хос ерөөл инженеринг ХХК гүйцэтгэсэн 1 төсөл, арга хэмжээний 2,670.8 мянган төгрөг зэрэг нийт 24,365.7 мянган төгрөгийг магадалшгүй ажлын хурлын тэмдэглэл, төсөв, акт зэрэг баримт материал байхгүй байхад гүйцэтгэгчид олгох санхүүжилтийн дүнд оруулан тооцож, чанарын баталгааны барьцаа болгон авч үлдсэн,
- Голден дрийм ХХК-ны гүйцэтгэсэн 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийн дүнд техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардлын 10,411.1 мянган төгрөг, захиалагчийн хяналтын зардлын 618.2 мянган төгрөг зэрэг нийт 11,029.3 мянган төгрөгийг оруулж тооцсон,

- Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК-ны гүйцэтгэсэн 1 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийн дүнд зураг, төсвийн үнэ 500.0 мянган төгрөгийг тус тус оруулан тооцсон байна. Дээрх зөрчлүүд нь гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгох эрсдэлийг үүсгэж байна.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.”, 42.5-д “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд **гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах** нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.”, 42.7.”Энэ хуульд зааснаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл гэрээний хүчинтэй хугацаанд **гүйцэтгэлийн баталгаа хүчингүй болох нөхцөл үүсвэл гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг зохих шаардлагад нийцүүлэн шинэчлэн гаргуулах**, хүчинтэй гүйцэтгэлийн баталгаагаар солих үүрэг хүлээнэ.”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.17 дахь “Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг **хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл**, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно”, гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний тусгай нөхцөлийн 4.11 “Чанарын баталгаат хугацаа 3 жил”, 4.15 “... Баталгаат хугацаа дуусаж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн ажилд гомдол санал гараагүй бол барьцаа гэрээний дүнгийн 5 хувийг олгоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Чанар баталгааны 5 хувийн барьцааны дүнд оруулан тооцсон баталгаажаагүй магадалшгүй ажлын зардал болон гүйцэтгэгчид олгох ёсгүй санхүүжилт зэрэг 35,895.0 мянган төгрөгийг ОНХС-ийн дансанд буцаан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 13,206.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 76,782.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн,

2,523.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	13,206.2	2	13,206.2	100.0
Албан шаардлага	6	76,782.0	6	76,782.0	100.0
Зөвлөмж	2	2,523.2	2	2,523.2	100.0
Нийт дүн	10	92,511.4	10	92,511.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг уг аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн” болон “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **34,385.0** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, ХХС-ийн зээлийн хүүгийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа: /34,385.0 мянган төгрөг/

- ХХС-ийн санхүүгийн тайланд 1,165.5.0 мянган төгрөгийн зээлийн хүүгийн орлогыг дутуу тайлагнасан,
- ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орон нутгийн төсвийн орлогод төвлөрөх ёстой 33,219.5 мянган төгрөгийн газрын дуудлага худалдааны ялагчийн дэнчингийн орлогыг авлагаар тайлагнасан.

Залруулаагүй алдаа:

- ХХС-ийн санхүүгийн тайланд зээлийн хүүгийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг; “, 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ХХС-ийн зээлийн хүүгийн орлогыг аккруэл сууриар хөтөлж, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **46,461.1** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **10,272.6** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **34,293.1** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **1** зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт:

5.1.1 Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **8,169.7** мянган төгрөгийг суутгаагүй байна. Үүнд:

- ЗДТГ нь орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **6,274.3** мянган төгрөгийг суутгалгүйгээр санхүүгийн тайланд авлага, өр төлбөрөөр тайлагнасан байна,
- Түнхэл тосгоны Захирагчийн алба – 1,281.7 мянган төгрөг,
- Хэрх тосгоны Захирагчийн алба – 613.7 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1: “... урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.1: “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Сумын ИТХ нь нарийн бичгийн дарга Б. Солонгод **2,102.9** мянган төгрөгийн цалин хөлс, урамшууллыг илүү олгосон байна. Үүнд:

- ИТХ-ын даргын 2024 оны 04 дүгээр захирамжаар 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр аймагтаа эхний байр эзэлсэн гэх үндэслэлээр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,272.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Тайлант оны 8 дугаар сард ээлжийн амралтын цалинтай давхардуулан 830.9 мянган төгрөгийн 5 хоногийн хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж олгосон.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3. “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшуулал болон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

5.2.1 ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс байгууллагын төсөвт төлөвлөн зарцуулах боломжтой дараах **17,264.8** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Төрийн албан хаагчдын зөвлөгөөний зардалд 12,528.8 мянган төгрөг,
- ✓ Тохижилтын буюу нохой устгалын зардалд 4,736.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.2 дахь “ ... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг **жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно.**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас үр дүнг тооцсон илтгэх хуудасгүйгээр төрийн албан хаагчийг чадавхжуулах гэх үндэслэлээр БНСУ-ын Сөүл хотод зохиогдсон “Тогтвортой газар тариалан ба байгаль орчныг сайжруулах” сургалтад чиг үүргийн бус үйлчлэгч, нярав, архив бичиг хэргийн ажилтан, төрийн захиргаа хууль эрх зүйн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтэн зэрэг 5 албан хаагчийг хамруулж, нийт **10,000.0** мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “Үр ашигтай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Сумын ИТХ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүй улмаас орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **1,712.7** мянган төгрөгийг суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй өглөг үүсгэсэн, урамшууллыг **121.5** мянган төгрөгөөр илүү олгож авлага үүсгэсэн .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ, 20.2.5: ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Дараах байгууллагууд нь өмнөх оны болон дараа оны зардлыг тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, нийт **3,673.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж зардлаар тайлагнасан байна. Үүнд:

- Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 2023 оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй халаалтын зардлын **1,873.0** мянган төгрөгийг нөхөн төлсөн,
- Сумын ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн торгуулийн багажны дата дугаарын 2025 оны төлбөрт "Юнител" ХХК-д **1,800.0** мянган төгрөгийг шилжүүлсэн атал урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2: бүх хөрөнгө, ... авлага, 14.4.3: бүх өр төлбөр" гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3.7 (г) дахь "зардлыг урьдчилан төлөх үед: Дт.Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/, Кт.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.5 Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **3,416.5** мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

Хэрх тосгоны Захирагчийн алба:

- ✓ Цахилгааны зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,700.0 мянган төгрөг,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардлаас мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 450.0 мянган төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 366.5 мянган төгрөг зэрэг нийт **2,516.5** мянган төгрөг,

ЗДТГ:

- ✓ Бараа үйлчилгээний бусад зардлаас мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 450.0 мянган төгрөг,

ИТХ:

- ✓ Бараа үйлчилгээний бусад зардлаас мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 450.0 мянган төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын хавсралтад заасан зардлын ангилал нэр төрлөөр бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, хянах зарчмыг алдагдуулж байна.

Өгсөн зөвлөмж: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлднэ.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС	2	1,165.5	1	1,165.5			1	1,165.5	1		1	
ЗДТГ	1	33,219.5			1	33,219.5	1	33,219.5				
Нийт дүн	3	34,385.0	1	1,165.5	1	33,219.5	2	34,385.0	1	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	2	27,267.8			2	27,264.8						
ИТХ	4	6,187.1	1	2,102.9	2	4,084.2	1	-				
ЗДТГ	2	6,724.3	1	6,274.3	1	450.0						
Хэрх тосгоны Захирагчийн алба	2	3,130.2	1	613.7	1	2,516.5						
Түнхэл тосгоны Захирагчийн алба	2	3,154.7	1	1,281.7	1	1,873.0						
Дүн	12	46,461.1	4	10,272.6	7	36,188.5	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Дүн							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
ТБОНӨХБАУХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой							
Чанар баталгааны 5 хувийн барьцааны дүнд баталгаажаагүй магадалшгүй ажлын зардал болон гүйцэтгэгчид олгох ёсгүй санхүүжилтийн дүнг оруулан тооцсон.	1	35,895.0			1	35,895.0	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой							
Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор видео контент, нэвтрүүлэг бэлтгэсэн, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	1	6,946.6			1	6,946.6	
Нийт дүн	2	42,841.6			2	42,841.6	

/мянган төгрөгөөр/